



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанлд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.16 № 1-6/406

Танай _____-ны № _____-т

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ
АРДЫН НАМД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох "Монгол Ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

"Монгол Ардын нам"-ын Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

442505363

2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн дүгнэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 1-6/524 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 2024 оны ээлжит сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулахгүйгээр оролцохоор ирүүлсэн тул “НИЙЦСЭН” дүгнэлтийг хүргүүлж байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Монгол Ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (...) -ийг хавсаргав.

Хувийг: Дорноговь аймгийн Монгол ардын намын хороонд

Хувийг: Дорноговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт:..... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ

Замын-Үүд сумын Монгол Ардын
Намын хорооны гишүүдийн 2024 оны
06-р сарын 22-ны өдрийн 01/06-р
тогтоолын хавсралт

Замын-Үүд сумын Монгол Ардын Намын
хорооны мөрийн хөтөлбөр

Монгол Улсын ээлжит 2024 оны сонгуулийн жилд Монгол Ардын намаас Улсын Их Хурлын сонгуульд оролцсон “Шинэ сэргэлтийн бодлого бүсчилсэн хөгжлийн реформ 2024-2028” мөрийн хөтөлбөр, Дорноговь аймгийн МАН-ын хорооноос Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд оролцох “Тогтвортой бодлого, тасралтгүй хөгжил” мөрийн хөтөлбөрийг үндэс болгосон,

Замын-Үүд сумын 2016-2024 оны хөгжлийг түүчээлж ирсэн “Хөгжлийн төлөө-Бид хамтдаа” үйл ажиллагааны хөтөлбөр, иргэдийн санал хүсэлтэд тулгуурлан, илүү эрчимтэй хөгжүүлэх зорилго, тооцоо судалгаанд үндэслэгдсэн, иргэдийн эрүүл мэнд, боловсрол, соёл, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн бүх талд хэрэгцээг хангах “Тогтвортой хөгжилд- Бид хамтдаа” мөрийн хөтөлбөрийг Замын-Үүд сумын Монгол Ардын Намын хорооноос Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор өргөн барьж байна.

Нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжлийн ололт амжилтыг бататган, тогтвортой, үр ашигтай өсөлтийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын төсөл, хөтөлбөр, төсөв санхүүгийн ухаалаг бодлогоор зангидан эх орны алтан босго Замын-Үүд нутгаа 2024-2028 онд илүү хурдацтай хөгжүүлэх арга хэмжээг бид энэхүү дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрөөрөө хэрэгжүүлнэ. Үүнд:

НЭГ. ЧАНАРТАЙ АМЬДРАЛ-ЖАРГАЛТАЙ ИРГЭН

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Хөдөлмөр эрхлэлт
- 1.4. Хүн амын бүлэг
- 1.5. Соёлын бодлого
- 1.6. Нийтийн биеийн тамир ба спорт

ХОЁР.ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 2.1. Уул уурхайн экспорт
- 2.2. Боомт, тээвэр логистик
- 2.3. Дэд бүтэц
- 2.4. Аялал жуулчлал
- 2.5. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
- 2.6. Санхүү, төсөв

ГУРАВ.ТҮМНИЙ ИТГЭЛ-ТӨРИЙН МАНЛАЙЛАЛ

- 3.1. Цахим-Дорноговь
- 3.2. Төрийн албаны бодлого
- 3.3. Иргэдийн оролцоо
- 3.4. Хүний эрх, Шударга ёс
- 3.5. Амар тайван, аюулгүй байдал
- 3.6. Гадаад харилцаа



ДӨРӨВ.ЭХ БАЙГАЛЬ-ЭЭЛТЭЙ ОРЧИН

- 4.1. Сумын ногоон хөгжил
- 4.2. Агаар, орчны бохирдлыг бууруулах менежмент
- 4.3. Ус ашиглалт, хамгаалалт
- 4.4. Хог хаягдлын менежмент

ТАВ.ӨРСӨЛДӨХ ЧАДВАР-ӨГӨӨЖТЭЙ ОРОН НУТАГ

- 5.1. Замын-Үүд-"SMART CITY"
- 5.2. "Аятай тухтай, аюулгүй орон нутаг"
- 5.3. Дорноговь аймгийн 10000 айлын орон сууц хөтөлбөр
- 5.4. "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөр

Мөрийн хөтөлбөр нь 5 хэсэг, 26 зүйл заалт бүхий зорилтоос бүрдсэн бодлогын бичиг баримт болно.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит
сонгуульд оролцох Замын-Үүд сумын Монгол Ардын Намын
хорооны "Тогтвортой хөгжилд-Бид хамтдаа"
мөрийн хөтөлбөр

НЭГ.ЧАНАРТАЙ АМЬДРАЛ-ЖАРГАЛТАЙ ИРГЭН

1.1. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нийтэд тэгш хүртээмжтэй хүргэж, бүгдийн эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлж хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

1.1.1 Нийгмийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсролыг тэгш хүртээмжтэй олгоно.

1.1.2 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг оношлогоо шинжилгээний хамралтыг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэн, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулна.

1.1.3 Иргэн, гэр бүлийн оролцоонд тулгуурлан хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, товлот дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вирус гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулна.

1.1.4 Олон улсын боомтоор хүн, амьтны шинэ болон сэргэж буй гоц халдварт өвчин хилээр нэвтрэх, улсын гүнд дамжин тархаас сэргийлж, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авах зорилгоор хилийн бүсийн сууринд 60 - аас багагүй ор бүхий стандартын шаардлага хангасан халдвартын эмнэлэг барина.

1.1.5 Эрүүл мэндийн байгууллагыг бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар хангана.

1.1.6 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтад хамруулна.

1.1.7 Анхан болон лавлагаа шатлалд орчин үеийн оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, өвдөгний үе солих, хавдрын бай эмчилгээ, хавдрын мэс засал зэрэг өндөр өртөгтэй тусламж үйлчилгээг нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.1.8 Сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи бүхий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.1.9 Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулан, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

1.1.10 Эрүүл мэндийн байгууллагуудад “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сүлжээний өргөтгөл, техник хэрэгслийн шинэчлэл хийж эрүүл мэндийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2. БОЛОВСРОЛ

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын тогтолцоог үе шаттай нэвтрүүлж, өв тэгш хүмүүжилтэй, монгол хүүхдийг, иргэнийг төлөвшүүлнэ.

1.2.1. Өндөр боловсрол, ур чадвартай багш нарыг бэлтгэх, урьж ажиллуулах зэрэг цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.2. Орон нутагт “Гүүр” төслийг хэрэгжүүлж, хөгжлийн тэргүүлэх чиглэлээр суралцагчдад гадаад, дотоодын сургалтын тэтгэлэг олгох асуудлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.3. Дижитал технологи дээр суурилсан тэгш хүртээмжтэй боловсролын системийг Ерөнхий боловсролын сургуулиудад байгуулна.

1.2.4. Ерөнхий боловсролын сургуулиудыг түшиглэн олон улсын Кембрижийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.5. Кембрижийн хөтөлбөртэй сургууль байгуулах хувийн хэвшлийн санаачлагыг дэмжинэ.

1.2.6. Суралцахуйд суурилсан сургалтын технологи, орчин бүрдүүлнэ.

1.2.7. “Англи хэлтэй Дорноговь” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.8. Байнгын ажиллагаатай өдөр өнжүүлэх төв байгуулна.

1.2.9. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр олон улсын хэлний сургалтын төв байгуулна.


1.2.10. Цэцэрлэг, сургуулийн гадна орчныг камержуулж, хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлнэ. \сайжруулж нэмэгдүүлнэ\

1.2.11. Цэцэрлэг, сургуулиудыг шинээр барьж анги дүүргэлтийг стандартын шаардлагад нийцүүлнэ.

1.2.12. ЕБ-ын бага сургуулийн биеийн тамирын заал барина.

1.2.13. “Сүү”, “Эрүүл чийрэг хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.14. Үдийн цай хөтөлбөр, СӨБ-ын хүүхдүүдийн нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг нэмэгдүүлнэ.



1.2.15. Насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагааг дэмжин төсөл хөтөлбөр дээр хамтран ажиллана.

1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Бизнес эрхлэгчдийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

1.3.1. Гарааны бизнесийг хөгжүүлэх зорилго бүхий “HUB” төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.3.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэх ажиллах хүчнийг сургах, бэлтгэх, ажлын байраар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3.3. “Ажлын гараа-Нутгийн хөгжил” хөтөлбөр, Их Дээд сургууль, коллеж төгсөгчид орон нутагтаа тогтвор сууршилтай ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ.

1.3.4. “Чадварлаг ажилтан-тогтвортой ажлын байр” хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ

1.3.5. “Халамжаас хөдөлмөрт” зорилтот арга хэмжээ үргэлжилнэ. Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогчид ажилтанд нийцтэй байдлаар тогтоож иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

1.4. ХҮН АМЫН БҮЛЭГ

Хүн амын бүлгүүдийн онцлог байдал, ялгаатай хэрэгцээнд нийцсэн бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хүний хөгжлийг дэмжинэ.

ГЭР БҮЛ-ХҮҮХЭД

1.4.1. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

1.4.2. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын болон гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах соёлыг төлөвшүүлнэ.

1.4.3. “Аав, эрчүүд”, “Чанартай амьдрал-аавуудын оролцоо” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.4.4. Хүүхэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг үргэлжлүүлэн “Child future” хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

1.4.5. Эцэг, эх, асран хамгаалагчид, иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.4.6. “Өсвөр үеийнхний сэтгэл зүйн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжигч аймаг” хөтөлбөрийг Замын-Үүд суманд хэрэгжүүлнэ.

1.4.7. Хүүхэд хөгжлийн цогцолбор төв байгуулна.

1.4.8. Төр хувийн хэвшлийн түншлэлээр хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагыг хангасан талбай байгуулна.

ЗАЛУУЧУУД

1.4.9. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

1.4.10. Залуучуудын хөдөлмөрлөх, бизнес эрхлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлнэ.

1.4.11. Төгсөгчдөд зориулан “Хийнгээ суръя-Орлого олъё-Хэмнэе” загвараар хөдөлмөрийн ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлнэ.

1.4.12. Дорноговь аймгийн “10000 Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд залуучуудыг байртай болгох бодлогыг хэрэгжүүлж, амьдрах нөхцөлийг сайжруулна.

1.4.13. Замын-Үүд суманд хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.

АХМАД НАСТАН

1.4.14. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор тодорхой хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.4.15. Ахмад настанг ажлын байраар хангасан төр, хувийн хэвшлийн байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.4.16. Мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ ИРГЭН

1.4.17. Тусгай хэрэгцээт хүүхдийн сэргээн засах эмчилгээний тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.

1.4.18. Тусгай хэрэгцээт иргэдийг түрээсийн орон сууц хөтөлбөрт хамруулна.

1.4.19. Тусгай хэрэгцээт иргэдийг ажлын байраар хангасан төр, хувийн хэвшлийн байгууллагыг бодлогоор дэмжинэ.

1.4.20. Шинээр баригдах бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний барилга байгууламжуудад Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан стандартыг мөрдүүлнэ.

1.5. СОЁЛЫН БОДЛОГО

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлж, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

- 1.5.1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.
- 1.5.2. Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээх, өвлөн уламжлуулах замаар олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.
- 1.5.3. Орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, оюуны үнэт өв бүтээлийг судлан илрүүлж, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- 1.5.4. Замын-Үүд суманд орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан музей, номын сан бүхий кино театр барина.

1.6. НИЙТИЙН БИЕЙН ТАМИР БА СПОРТ

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгоно.

- 1.6.1. Иргэдэд үйлчлэх спортын болон нийтийн биеийн тамирын зориулалтын стандарт талбай, барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 1.6.2. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл, идэвхтэй зан үйлийг төлөвшүүлэх, иргэдийг дасгал хөдөлгөөн хийхэд уриалах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.6.3. Хөдөлгөөн засал, йог, фитнес, хийн дасгал, нийтийн бүжиг зэрэг иргэдийн эрүүл мэнд, хөдөлгөөн заслыг дэмжсэн үйл ажиллагааг тогтвортой явуулдаг иргэд аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 1.6.4. Замын-Үүд суманд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөл бөмбөгийн стандартын талбай байгуулна.

ХОЁР. ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2.1. УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

Байгаль орчинд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайн экспортын үйл ажиллагааг дэмжинэ.

- 2.1.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын зөвшөөрөл олгоход орон нутгийн иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэдэг зарчмыг баримтална.

- 2.1.2. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, олон нийтийн хяналтын дор техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийнэ.
- 2.1.3. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг байгаль, хүн амд ээлтэй бодлогоор хэрэгжүүлж, нурмаг ачааны гаалийн хяналтын бүс, талбайг сумын иргэдийн суурьшлын бүсээс гаргана.
- 2.1.4. Авто замын боомтоор нэвтрэх экспорт, аюултай ачааны гарцыг бий болгоно.

2.2. БООМТ, ТЭЭВЭР ЛОГИСТИК

Боомтын сэргээлтийг эрчимжүүлэн нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлж, тээврийн дэд бүтцийн сүлжээг өргөжүүлнэ.

- 2.2.1. Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд хамтран ажиллана.
- 2.2.2. УБТЗамын Замын-Үүд зангилааны өргөтгөл, шинэчлэлтийг хийж, ачаа тээврийн эргэлтийг нэмэгдүүлнэ.
- 2.2.3. УБТЗ-тай хамтран 1109 км- ийн гармыг 2 өөр түвшинд огтлолцуулж нүхэн гарц хийнэ.
- 2.2.4. УБ-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн автозамын нэвтрэн өнгөрүүлэх цэгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, 4 эгнээ бүхий авто зам байгуулна.

2.3. ДЭД БҮТЭЦ

Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахад тархмал эх үүсвэрийг ашиглан эрчим хүч, дулаан хангамжийн аюулгүй, найдвартай байдлыг нэмэгдүүлж, автозамын сүлжээг өргөтгөнө.

- 2.3.1. Сумын суурьшлын бүсийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэчилнэ.
- 2.3.2. Сумын суурьшлын бүс дэх хэрэглэгчдэд хүргэх шугам сүлжээг өргөтгөж, шинээр хэрэглэгчидийн 50-ийг хангана.
- 2.3.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг барьж байгуулна.
- 2.3.4. Төвийн эрчим хүчний тог тасарсан тохиолдолд сэргээгдэх эрчим хүчний үйл ажиллагаа явуулдаг Наран тээг ХХК-ийн эх үүсвэрээр шийдвэрлэнэ.

- 2.3.5. Сумын суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, дугуйн болон явган хүний замын сүлжээг нэмэгдүүлнэ.
- 2.3.6. "Гэрэлтэй Замын-Үүд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.3.7. Суурьшлын бүс дэх агаарын шугамыг цэгцэлж, нэгдсэн худаг сувагчлал хийнэ
- 2.3.8. Ундны усны нөөцийг нэмэгдүүлж 3000 м³ багтаамж бүхий усан сан байгуулна.
- 2.3.9. Гэр хорооллын тэгш гудамж төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.3.10. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, хэрэгжилтийг хангана.
- 2.3.11. Ачааны автомашины нэгдсэн зогсоол, үйлчилгээний төвийг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.

2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Байгаль, түүх, шашин, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.

- 2.4.1. Хил орчмын аялал жуулчлалыг төр хувийн түншлэлээр хөгжүүлж орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.4.2. Аялал, жуулчлалын агентлаг, аяллын тур операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэнг бэлтгэхэд орон нутгийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.3. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн, худалдаа, үйлчилгээний онцлог бүхий аялал жуулчлалын төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 2.4.4. Олон улсын морин тойруулгыг төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.
- 2.4.5. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

2.5. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлж, гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас хангаж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

- 2.5.1. Хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг байгуулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжин ажиллана.

- 3.1.1. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “ухаалаг E-Mongolia” системийг хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН”, 24/7 цагаар ажиллах “СМАРТ” цэг, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжүүдийг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 3.1.3. Төрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд инновацийг нэвтрүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлж, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлнэ.

3.2. ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

- 3.2.1. Сумын “Ээлтэй Замын-Үүд” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ
- 3.2.2. Орон нутагт ажиллаж байгаа “Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр” үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.3. Төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлж, цогц чадамжтай хүний нөөцийг бүрдүүлнэ.
- 3.2.4. Гадаад улсын ижил төстэй байгууллагын үйл ажиллагаатай танилцах, урт, богино хугацааны сургалтад төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “Маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг хамруулах бодлого баримтална.
- 3.2.5. Төрийн албан хаагчдыг ажилласан жил, ажлын үр дүнг харгалзан түрээсийн орон сууцанд хамруулна.

3.3. ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 3.3.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.3.2. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 3.3.3. Олон нийтийн оролцоо, төсвийн ил тод байдлыг хангасан “Иргэдийн төсөв”-ийг боловсруулна.

- 3.3.4. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 3.3.5. Иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлнэ.

3.4. ХҮНИЙ ЭРХ, ШУДАРГА ЁС

Орон нутгийн түвшинд хүний эрхэд суурилсан хандлагаар аливаа үйл ажиллагааг явуулж, хүний эрхийн зөрчилтэй тууштай тэмцэнэ.

- 3.4.1. Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлж, тогтмол үнэлгээ хийн түүнд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4.2. Зорилтод бүлгийн эрхийг хангах, эрхийн зөрчлөөс сэргийлэх, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх ажлыг бүх түвшинд зохион байгуулна.
- 3.4.3. Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох орон нутгийн тогтолцоог хөгжүүлж, хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтална.

3.5. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Үндэсний аюулгүй байдлыг орон нутгийн бүх бодлогод тусган хэрэгжүүлэх зарчмыг баримтална.

- 3.5.1. Хүнсний хувьсгалыг хэрэгжүүлж, аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.
- 3.5.2. Усан сан, усны нөөц эх үүсвэрийг хамгаалах аюулгүй байдлыг хангана.
- 3.5.3. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хадгалж угийн бичиг хөтлөх аянд гэр бүлийг идэвхтэй хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

Аливаа гэмт хэрэг зөрчил, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, хандлагыг төлөвшүүлж амар тайван аюулгүй орчныг бүрдүүлнэ.

- 3.5.4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгааныг арилгах, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

- 3.5.5. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлж, замын хөдөлгөөнд оролцогчдын хандлага, соёл, хариуцлагыг дээшлүүлж, зам тээврийн ослыг бууруулах
- 3.5.6. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргаж, хүүхдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.
- 3.5.7. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гаднын сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.5.8. Аюулгүй орчныг бий болгох зорилгоор камержуулалтыг нэмэгдүүлж, “аюулгүй ногоон бүс” -ийг байгуулна.

Эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, эх орноо батлан хамгаалах үзэл хандлагыг төлөвшүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

- 3.5.9. Цэргийн насны залууст эх оронч үзлийг төлөвшүүлж цэрэг спортын Дөл тэмцээнийг тогтмол зохион байгуулна.
- 3.5.10. Эрх орноо батлан хамгаалах, эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх “Эх орны босго” хөтөлбөр хэрэгжүүлж ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчдыг хамруулна.
- 3.5.11. Монгол улсын төрийн далбааг хүндэтгэн залах ёслолын өдрүүдийг бий болгоно.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулж эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлнэ.

- 3.5.12. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.
- 3.5.13. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.5.14. Иргэдээ эх оронч сэтгэл, хандлагатай болгох, орон нутгаа хамгаалах, гамшиг, эрсдэлтэй нөхцөлд бүх нийтийн бэлэн байдлын чадавхыг дээшлүүлж, бие бялдрын хөгжлийг нь дэмжиж, иргэний боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.6. ГАДААД ХАРИЛЦАА

Хөрш болон өндөр хөгжилтэй орнууд тэдгээрийн муж, хотуудтай хамтын ажиллагаа хөгжүүлэн, олон тулгуурт гадаад харилцааны бодлогыг хэрэгжүүлж, сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6.1. “Нэг цонх-Нэгдмэл гадаад бодлого”-ыг үргэлжлүүлж, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хоттой тогтоосон түншлэлийг эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд өргөжүүлнэ.

3.6.2. ОХУ, АНУ, Япон, БНСУ, Турк зэрэг улс орнуудтай “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.6.3. Хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, бизнес, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт гадаад түншлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ЭКОЛОГИЙН БҮС - ЭЭЛТЭЙ ОРЧИН

4417144353
EЮA0056 9025707

4.1. НОГООН ХӨГЖИЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог ханган ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

4.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон Замын-Үүд” хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлнэ.

4.1.2. Ногоон байгууламжийн арчилгаа усалгаанд Замын-Үүд дулааны станц УҮГ-аас гарч буй саарал усыг ашиглана.

4.1.3. Замын-Үүд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд Экологийн бүсийг байгуулна.

4.1.4. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр ногоон байгууламжийн агро парк байгуулна.

4.1.5. Тэжээлийн ургамал тариалах зориулалт бүхий 100 га хүртэл газрыг газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд оруулж тариалалт хийх иргэн, ААН-ийн санаачлагыг дэмжин ажиллана.

4.2. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТ

Агаар, орчны бохирдлыг үүсгэгч эх үүсвэрүүдийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

4.2.1. Ногоон хөгжлийн шийдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боловсрол олгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.2. Хот, суурин газарт агаар, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг арилгах ажлыг бүх түвшинд нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.3. Дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөр болон хүртээмжтэй орон сууцны бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2.4. Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3. УС АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Усны нөөцийг хамгаалах, бохирдол, хомсдолдоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна.

4.3.1. Усны сан бүхий бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг хэрэгжүүлнэ.

4.3.2. Замын-Үүд дулааны станц УҮГ-ын ус цэвэршүүлэх байгууламжаас сумын хүн амыг ундны цэвэр усаар хангуулах ажлыг эхлүүлнэ.

4.3.3. Замын-Үүд дулааны станц УҮГ-т усны чанарын иж бүрэн шинжилгээний лаборатори байгуулна.

4.4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглах санаачилгуудыг дэмжин байгальд ээлтэй техник технологийг нэвтрүүлж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

4.4.1. Иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн хогийн цэгийг дарж булах, ил задгай хаягдах хаягдлын хэмжээг бууруулна.

4.4.2. Замын-Үүд сумдын хог хаягдлын ландфилл технологийг нэвтрүүлж, бүрэн шаталттай зуух суурилуулна.

ТАВ.ӨРСӨЛДӨХ ЧАДВАР-ӨГӨӨЖТЭЙ ОРОН НУТАГ

5.1. ЗАМЫН-ҮҮД-"SMART CITY"

5.1.1. Замын-Үүд суманд хувийн хэвшилтэй хамтран шинэ суурьшлын бүсэд "ECO", "HYBRID", "HOUSE TOWN" амины орон сууцны хорооллыг шинээр байгуулна.

5.1.2. Замын-Үүд сумыг "SMART CITY" болгох ажлыг эхлүүлднэ.

5.1.3. Замын-Үүд хилийн боомтын нэвтрэх чадварыг сайжруулах зорилгоор хилийн хяналтын байгууллагуудын бүртгэлийг цахимжуулна.

5.1.4. Улс хооронд тээвэрлэлт хийж буй хүнд даацын автотээврийн хэрэгслийг цахимаар бүртгэх машины зогсоол, дарааллын системд камер, мэдрэгч төхөөрөмжүүдийг ашиглан хилийн боомтын нэвтрэлтийг сайжруулна.

5.2. "АЯТАЙ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ" ОРОН НУТАГ

Хөдөөгийн сэргэлтийн бодлогыг эрчимжүүлж, орон нутагт аятай тухтай, аз жаргалтай амьдрах ээлтэй орчныг бүрдүүлднэ.

5.2.1. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг холбогдох стандартад нийцүүлднэ.

5.2.2. Дахин төлөвлөлтөд хамрагдах гэр хорооллуудад газар чөлөөлөлт хийж, зохион байгуулалтыг сайжруулна.

- 5.2.3. Хууль бусаар олгосон газрыг төрд буцаан авах, нийтийн эзэмшлийн газар, талбайд зөвшөөрөлгүй барьсан байгууламжийг буулгах ажлыг үргэлжлүүлж, уг газарт ногоон байгууламж барина.
- 5.2.4. Хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүл "Сурагчийн автобус" үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 5.2.5. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах, шугам сүлжээний засвар шинэчлэлтийг СӨХ, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 5.2.6. Тогтмол ажиллагаатай оршин суугчдын оролцоонд тулгуурласан СӨХ-ийг орон нутгаас дэмжинэ.
- 5.2.7. "Хашаандаа сайхан амьдарья" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.3. ДОРНОГОВЬ АЙМГИЙН 10000 АЙЛЫН ОРОН СУУЦ ХӨТӨЛБӨР

Иргэдийг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангана.

- 5.3.1. "Мандах наран хороолол" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.3.2. УБТЗ-ын ХНН-тэй хамтарч "Говийн төмөр замчид орон сууцны хөтөлбөр" хэрэгжүүлнэ.
- 5.3.3. Замын-Үүд суманд хот хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу амины орон сууцны хороолол байгуулна.
- 5.3.4. Замын-Үүд суманд "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 5.3.5. Боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд Хилийн хяналтын байгууллагуудын ажиллагсадын орон сууц, өдөр өнжүүлэх төв баригдана.

5.4. ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН ХӨТӨЛБӨР

Байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах, малчдыг дэмжих "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

- 5.4.1. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана.

- 5.4.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг менежментийн аргаар удирдах хоршоо фермер компанийн сүлжээний зарчимд шилжүүлэн хөгжүүлэх бодлого баримтална.
- 5.4.3. Хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын "Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд малчид дундын худаг, усжуулах цэгийг байгуулна
- 5.4.4. Хоршоололд суурилсан хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4417144353
EUA0056 9025707

ЗАМЫН-ҮҮД СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103

Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.16

№

1-6/407

Танай _____

-ны № _____

-т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох “Монгол Ардын нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Монгол Ардын нам”-ын Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

442505365

2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн дүгнэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 1-6/511 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 2024 оны ээлжит сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулахгүйгээр оролцохоор ирүүлсэн тул “НИЙЦСЭН” дүгнэлтийг хүргүүлж байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Монгол Ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (...) -ийг хавсаргав.

Хувийг: Дорноговь аймгийн Монгол ардын намын хороонд

Хувийг: Дорноговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт:.....⁷ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Дэлгэрэх сумын Монгол ардын намын хорооны
2024 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн
01 дүгээр тогтоолын хавсралт



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН БАЙГУУЛЛАГЫН
“ДЭЛГЭРЭХ ХӨГЖИЛ-2”
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ.ЧАНАРТАЙ АМЬДРАЛ-ЖАРГАЛТАЙ ИРГЭН

- 1.1. Эрүүл мэнд
- 1.2. Боловсрол
- 1.3. Хөдөлмөр эрхлэлт
- 1.4. Нийгэм
- 1.5. Соёл
- 1.6. Нийтийн биеийн тамир ба спорт

ХОЁР.ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

- 2.1. Үйлдвэрлэл үйлчилгээ
- 2.2. Уул уурхай
- 2.3. Дэд бүтэц
- 2.4. Аялал жуулчлал
- 2.5. Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ
- 2.6. Санхүү, төсөв

ГУРАВ.ТҮМНИЙ ИТГЭЛ-ТӨРИЙН МАНДАЙЛАЛ

- 3.1. Цахим-Хөгжил
- 3.2. Төрийн албаны бодлого
- 3.3. Иргэдийн оролцоо
- 3.4. Хүний эрх, Шударга ёс
- 3.5. Амар тайван, аюулгүй байдал
- 3.6. Гадаад харилцаа

Утас: 4353
ЕЮА0056 9025707

ДӨРӨВ.ЭХ БАЙГАЛЬ-ЭЭЛТЭЙ ОРЧИН

- 4.1. Ногоон хөгжил
- 4.2. Агаар, орчны бохирдлыг бууруулах менежмент
- 4.3. Бэлчээрийн менежмент
- 4.4. Ус ашиглалт, хамгаалалт
- 4.5. Хог хаягдлын менежмент

ТАВ.ӨРСӨЛДӨХ ЧАДВАР-ӨГӨӨЖТЭЙ ОРОН НУТАГ

- 5.1. Хөдөөгийн сэргэлт
- 5.2. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөр

НЭГ.ЧАНАРТАЙ АМЬДРАЛ-ЖАРГАЛТАЙ ИРГЭН

1.1. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэн, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлнэ.

- 1.1.1 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрүүл мэндийн боловсролыг тэгш хүртээмжтэй олгоно.
- 1.1.2 Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээний хамралтыг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэн, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулна.
- 1.1.3 Иргэн, гэр бүлийн оролцоонд тулгуурлан хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, товлот дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын өвчлөл, сүрьеэгийн тохиолдлыг бууруулна.
- 1.1.4 Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадварыг нэмэгдүүлэн гадаад, дотоодын сургалтад хамруулна.
- 1.1.5 Анхан болон лавлагаа шатлалд орчин үеийн оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, хангалтыг сайжруулна.
- 1.1.6 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог бэхжүүлж халдварт өвчнийг бууруулна.
- 1.1.7 “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сүлжээний өргөтгөл, техник хэрэгслийн шинэчлэл хийж эрүүл мэндийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.8 Орон нутагт дутагдалтай мэргэжлээр суралцах оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.9 Эм эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллана.
- 1.1.10 Эрүүл мэндийн төвийг дотор болон ойрын дуудлага, үйлчилгээнд зориулсан эдийн засагт хэмнэлттэй автомашинаар хангана.
- 1.1.11 Эрүүл мэндийн төвийн хуучин барилгад их засвар хийнэ.
- 1.1.12 Боловсон хүчний хангалтыг сайжруулж орон сууцаар хангана.
- 1.1.13 Шүдний кабинет байгуулан ажиллах эмч, мэргэжилтний санал санаачилгыг дэмжинэ.
- 1.1.14 Эрүүл мэндийн төвийн гадна хайсыг шинэчилнэ.

1.2. БОЛОВСРОЛ

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын тогтолцоог үе шаттай нэвтрүүлж, өв тэгш хүмүүжилтэй, монгол хүүхдийг төлөвшүүлнэ.

- 1.2.1. Багш нарын ур чадвар, мэргэшлийг дээшлүүлэх сургалт хөтөлбөрт хамруулж сургалтын үнэлгээний чанарыг дээшлүүлнэ.
- 1.2.2. Орон нутагт хомсдолтой мэргэжлээр суралцагчдад гадаад, дотоодын сургалтын тэтгэлэг олгох асуудлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.3. Дижитал технологи дээр суурилсан тэгш хүртээмжтэй боловсролын системийг хөгжүүлнэ.

- 1.2.4. Суралцахуйд суурилсан сургалтын технологи, орчин бүрдүүлнэ.
- 1.2.5. “**Үдийн хоол**” хөтөлбөрийг чанаржуулан, орон нутгаас нэмэлтээр санхүүжилт олгож, хоолны шим тэжээлийг нэмэгдүүлнэ.
- 1.2.6. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.2.7. Суманд 320 хүүхдийн Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулна.
- 1.2.8. Хүүхдийн цэцэрлэгийн барилгад гадна их засвар хийж хашаа хайсыг шинэчилнэ.
- 1.2.9. Боловсролын байгууллагын боловсон хүчний хангалтыг сайжруулна.
- 1.2.10. Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-д ус цэвэршүүлэгч суурилуулж цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.
- 1.2.11. Шаардлагатай хэрэглэгдэхүүний хангалтыг тухай бүр шийдвэрлэж сургалтын хүртээмжийг сайжруулна.
- 1.2.12. Суралцагчдад эко боловсрол олгох хөтөлбөр, сургалтыг хэрэгжүүлж байгаль орчиндоо ээлтэй иргэн болж төлөвших суурийг тавина.

1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Бизнес эрхлэгчдийг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг тууштай бууруулна.

- 1.3.1. Суманд хэрэгжүүлж байгаа томоохон төсөл хөтөлбөр, бүтээн байгуулалтын захиалгат ажил үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх бодлогыг барьж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 1.3.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэх ажиллах хүчнийг сургаж бэлтгэн ажлын байраар хангах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3. Орон нутагт хэрэгцээ шаардлага бүхий үйлдвэрлэл, цехүүдийг байгуулахад иргэд, ААН-ийг бодлогоор дэмжиж хамтарч ажиллана.
- 1.3.4. “**Халамжаас хөдөлмөрт**” зорилтот арга хэмжээгүргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Цагийн ажил, түр ажлын байрны зохицуулалтыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар тогтоон иргэдийн нэмэлт орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.5. “**Дэлгэрэхэд үйлдвэрлэв**” нутгийн брэнд бүтээгдэхүүн худалдан борлуулах үйлчилгээний цэгийг байгуулж үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 1.3.6. Зочид буудал, зоогийн газар нээн ажиллуулах хүсэлтэй ААН, иргэдийн санал санаачилгыг дэмжин төр, иргэн, хувийн хэвшлийн оролцоотойгоор хөрөнгийг шийдвэрлэж хамтарч ажиллана.

1.4. НИЙГЭМ

Хүн амын бүлгүүдийн онцлог байдал, ялгаатай хэрэгцээнд нийцсэн бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хүний хөгжлийг дэмжинэ.

ГЭР БҮЛ-ХҮҮХЭД

- 1.4.1. Идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

- 1.4.2. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын болон гэр бүлийн харилцаанд жендерийн эрх тэгш байдлыг хангах соёлыг төлөвшүүлнэ.
- 1.4.3. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.4. Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.4.5. Эцэг, эх, асран хамгаалагчид, иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.4.6. Сум хариуцсан хүүхэд хамгааллын ажилтантай болгоно.
- 1.4.7. Эцэг эх, ЕБС, төрийн байгууллагын оролцоотой хүүхдүүдэд Төрийн болон хувийн өмч хөрөнгийг хайрлан хамгаалах сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлж эерэг хандлагыг төлөвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.8. Гэр бүл, хүүхдүүдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарна.
- 1.4.9. Жаргалан зусланд хүүхдүүдийг амраах, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

ЗАЛУУЧУУД

- 1.4.10. Залуучуудын хөдөлмөрлөх, бизнес эрхлэх боломж нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 1.4.11. “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд залуучуудыг байртай болгох бодлогыг хэрэгжүүлж, амьдрах нөхцөлийг сайжруулна.
- 1.4.12. Орон нутгийн залуу боловсон хүчин, гэр бүлүүдийг сумандаа ажиллах амьдрах нөхцөлөөр хангах зорилгоор орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.4.13. Залуу гэр бүлүүдийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлж амьдрах нөхцөлийг сайжруулна.
- 1.4.14. Залуучуудын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж залуусын нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, төрөл бүрийн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх.

АХМАД НАСТАН

- 1.4.15. Хуучин гандангийн барилгыг засвар, тохижилт хийж төвлөрсөн инженерийн шугамд холбоон “Ахмадын өргөө” болгоно.
- 1.4.16. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.17. Ахмадад үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.
- 1.4.18. Аймагт шинээр баригдсан ахмадын сувилалд ахмадуудыг хамруулна.
- 1.4.19. Ахмадын холбооны үйл ажиллагааг тогтмолжуулна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН

- 1.4.20. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадамжид суурилсан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.4.21. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.4.22. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагаас үйлчилгээ авахад ээлтэй орчныг бүрдүүлнэ.

1.5. СОЁЛ

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлж, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

- 1.5.1. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэн, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлнэ.
- 1.5.2. Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, сэргээх, өвлөн уламжлуулах замаар олон нийтэд түгээн дэлгэрүүлнэ.
- 1.5.3. Орон нутгийн түүх соёлыг илэрхийлсэн бүтээл туурвих, оюуны үнэт өв бүтээлийг судлан илрүүлж, олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- 1.5.4. “Алтан говийн унага” соёлын төвийн барилгыг ашиглалтад оруулж, иргэдийн соёл урлагийн үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлнэ
- 1.5.5. Хөгжим, дуу, бүжиг, жүжиг, үндэсний болон сонгодог урлагийн бүтээл туурвих нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн чадварлаг уран бүтээлчдээр орон тоог нөхөн хангаж, соёл урлагийн үйлчилгээний менежмент, чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.5.6. Айл бүр угийн бичиг хөтлөх зорилтот хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.5.7. “Морин хууртай Дэлгэрэх” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.8. “Авьяаслаг Дэлгэрэхчүүд” урлагийн наадмыг жил бүр тогтмол зохион байгуулна
- 1.5.9. ЕБС, Соёлын төвийг түшиглэн урлаг соёлын төрөл бүрийн дугуйлан, сургалтыг зохион байгуулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.5.10. Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах болзолт уралдаан, наадмыг зохион байгуулна.
- 1.5.11. Номын сангийн танхимыг стандартад нийцүүлэн тохижуулж үйл ажиллагааг сайжруулан иргэдийн ном унших дадлыг сэргээх нөлөөллийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.5.12. Шинээр баригдах соёлын төвийг түшиглэн төв талбайг байгуулна.
- 1.5.13. Орон нутаг судлалын танхимын үзмэрийг нэмэгдүүлнэ.

1.6. НИЙТИЙН БИЕЙН ТАМИР БА СПОРТ

Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгоно.

- 1.6.1. Иргэдэд үйлчлэх спортын болон нийтийн биеийн тамирын зориулалтын талбай, барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.
- 1.6.2. Аймаг, бүсийн чанартай спортын тэмцээн уралдааныг орон нутагтаа зохион байгуулна.
- 1.6.3. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл, идэвхтэй зан үйлийг төлөвшүүлэх, иргэдийг дасгал хөдөлгөөн хийхэд уриалах нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.6.4. Сумыг нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгоно.

- 1.6.5. “Нийтийн биеийн тамир” арга хэмжээг тогтмол жил бүр зохион байгуулна.
- 1.6.6. Орон нутгаа төлөөлөн гадаад, дотоодын спортын уралдаан тэмцээнд оролцогчдыг бодлогоор болон хөрөнгө санхүүгээр дэмжиж ажиллаж амжилт үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 1.6.7. Үндэсний болон бусад Спорт холбоодын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааг сэргээн тогтмолжуулна.
- 1.6.8. Спортын секц, дугуйлангуудыг тогтмол хичээллүүлнэ.

ХОЁР.ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2.1.ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хөгжүүлж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгон дотоодын хэрэгцээг хангана.

- 2.1.1. Төр, хувийн хэвшлийн оролцоотой жижиг, дунд үйлдвэр, цехүүдийг байгуулж зах зээлд бүтээгдэхүүнийг нийлүүлэх замаар иргэдийн орлого, амьжиргааг дээшлүүлнэ.
- 2.1.2. Бүх салбар, чиглэлийн үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэх иргэд, ААН-үүдийн санаачилгыг дэмжин ажиллаж ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.1.3. Гарааны бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллана.

2.2.УУЛ УУРХАЙ

Байгаль орчинд ээлтэй, ил тод, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжиж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

- 2.2.1. Байгальд ээлтэй, хариуцлагатай уул уурхай болон стратегийн ач холбогдолтой төслүүдийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.2.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход орон нутгийн иргэдийн саналд үндэслэн шийдвэрлэдэг зарчмыг баримтална.
- 2.2.3. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, олон нийтийн хяналтын дор техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үргэлжлэн хийнэ.
- 2.2.4. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг байгаль орчинд ээлтэй “Нэг бүс-Нэг зам” бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.2.5. Уул уурхайн компаниудтай нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан, орон нутгийн хөгжлийн санд хандив, орлого төвлөрүүлж эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.6. Уул уурхайн компаниудад шаардлагатай хүний нөөц, хүнс болон бусад материаллаг хэрэгцээг орон нутгаас хангах бодлогыг барьж ажиллана.

2.3. ДЭД БҮТЭЦ

Үүрэн телефон, Эрчим хүч, дулаан хангамжийн аюулгүй, найдвартай байдлыг хангана.

- 2.3.1 Галшар-Дэлгэрэх чиглэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуурыг бетон тулгуураар сольж цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангана.
- 2.3.2 “Чандмань илч” ОНӨХК-ийн сум дахь салбарын уурын зуухны чадлыг нэмэгдүүлнэ.
- 2.3.3 Сумын төвийн төвлөрсөн инженерийн шугам сүлжээний өргөтгөлийг хийж айл өрх, албан байгууллагуудыг холбох ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 2.3.4 Сумын төвд цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл, шинэчлэл шаардлагатай цэгүүдийг тодорхойлж өргөтгөл, шинэчлэлийг хийнэ.
- 2.3.5 Камержуулалтын нэгдсэн системд парк шинэчлэл хийнэ.
- 2.3.6 Гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлж ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.
- 2.3.7 Үүрэн телефоны сүлжээг өргөтгөнө.

2.4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Байгаль, түүх, шашин, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.

- 2.4.1. Байгалийн өвөрмөц тогтоц бүхий Цонжийн чулууг түшиглэн амралтын бааз байгуулж дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг хэрэгжүүлснээр иргэд, ААН-үүдийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.4.2. Орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулж, орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.4.3. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.4. Маналын найман суваргыг түшиглэн аяллын отог, цэг байгуулна.

2.5. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлж, гол нэрийн зарим хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгаас хангаж, импортыг орлох, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

- 2.5.1 Хөдөө аж ахуйн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.5.2 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг сурталчилж шаардлагатай малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэх бодлого баримтална.
- 2.5.3 Нэмүү өртөг шингэсэн мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, цех байгуулах иргэд, ААН-үүдийг бүх талаар дэмжиж ажиллана.
- 2.5.4 Малжуулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.5.5 Малчдын хоршоо байгуулах ажлыг бодлогоор дэмжиж эрчимжсэн болон хагас эрчимжсэн аж ахуй эрхлэх талаар төсөл хөтөлбөрт хамруулна.

- 2.5.6 Хадлангийн салаа байгуулах, орон нутгийн малчид, иргэдийн өвс, ногоон тэжээлийн хэрэгцээг хангах иргэн, ААН, хоршоодыг дэмжиж шаардлагатай техник хэрэгслээр хангана.
- 2.5.7 “Шинэ хөдөө төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж хүлэмжийн аж ахуй эрхлэлт, хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж орон нутгийн хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Мал, амьтны тандалт, хяналт үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлж, өвчний тархалтыг хязгаарлана.

- 2.5.8 Малын эрүүл мэндийг хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, мал, амьтныг гоц халдварт болон халдварт өвчний төлөвлөгөөт вакцинд бүрэн хамруулна.
- 2.5.9 Малын гоц болон халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, угаалга, туулгалт, боловсруулалтын ажлыг технологит хугацаанд үр дүнтэй зохион байгуулна.
- 2.5.10 “Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг төв”-ийг байгуулна.
- 2.5.11 Дэлгэрэхийн улаан ямаа омгийн цөм сүргийг хамгаалах, өсгөх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулна.
- 2.5.12 Дэндэв тайж, Галсанбанди адууг хурдны омгоор баталгаажуулах эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үргэлжлүүлж баталгаажуулна.

2.6. САНХҮҮ, ТӨСӨВ

Орон нутгийн санхүү, төсвийн бодлогыг иргэдэд хүртээмжтэй төлөвлөж зарцуулна.

- 2.6.1 Олон нийтийн оролцоо, хяналтыг бүрдүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бэхжүүлнэ.
- 2.6.2 Төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж төсвийн сахилга, хяналт хариуцлагыг сайжруулна. 4417144353
EЮА0056 9025707
- 2.6.3 Хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлан таниулж, санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.
- 2.6.4 Татвар төлөгчийн бүртгэл, тайлан, татвар төлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах боломжийг бүрдүүлж, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.

ГУРАВ.ТҮМНИЙ ИТГЭЛ-ТӨРИЙН МАНЛАЙЛАЛ

3.1. ЦАХИМ ХӨГЖИЛ

Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.

- 3.1.1. “Цахим Дорноговь” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Төрийн бүх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоогүй, хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “ухаалаг E-Mongolia” системийг хэрэгжүүлнэ.
- 3.1.3. Төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН”, 24/7 цагаар ажиллах “СМАРТ” цэгийн тоог нэмэгдүүлж, киоск, хөдөлгөөнт цэг, төхөөрөмжүүдийг үе шаттай нэмэгдүүлнэ.

- 3.1.4. Төрөөс иргэн, бизнест үзүүлж буй гол үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж цахимжуулах, хиймэл оюун ухаан ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна.
- 3.1.5. Төрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд инновацыг нэвтрүүлж, цахим шилжилтийг эрчимжүүлж, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлнэ.
- 3.1.6. Төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор КИОСК машиныг нэвтрүүлнэ.

3.2.ТӨРИЙН АЛБАНЫ БОДЛОГО

- 3.2.1. “Төрийн захиргааны албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилтот хөтөлбөр” үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.2. “Иргэн төвтэй” төрийн үйлчилгээг хэрэгжүүлж, нэг цэгээс цогц үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулна.
- 3.2.3. Төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлж, цогц чадамжтай хүний нөөцийг бүрдүүлнэ.
- 3.2.4. Төрийн албан хаагчдыг ажилласан жил, ажлын үр дүнг харгалзан түрээсийн орон сууцанд хамруулна.
- 3.2.5. ЗДТГ-ын барилгыг их засварт оруулснаар төрийн албан хаагчийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж иргэдэд үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

3.3.ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 3.3.1. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.3.2. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 3.3.3. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 3.3.4. Иргэний өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлэх тогтолцоог бэхжүүлнэ.

3.4.ХҮНИЙ ЭРХ, ШУДАРГА ЁС

Орон нутгийн түвшинд хүний эрхэд суурилсан хандлагаар аливаа үйл ажиллагааг явуулж, хүний эрхийн зөрчилтэй тууштай тэмцэнэ.

- 3.4.1. Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлыг тодорхойлж, тогтмол үнэлгээ хийн түүнд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4.2. Зорилтод бүлгийн эрхийг хангах, эрхийн зөрчлөөс сэргийлэх, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх ажлыг бүх түвшинд зохион байгуулна.

- 3.4.3. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох орон нутгийн тогтолцоог хөгжүүлж, хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтална.
- 3.4.4. Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаална.

Иргэн бүрийн илүү сайхан ирээдүй, эрх тэгш боломжийн төлөө Авлигын эсрэг тууштай тэмцлийг орон нутагт үргэлжлүүлнэ.

- 3.4.5. Төрийн албаны хүнд суртлыг арилгах, төрийн албанд хууль бусаар томилогдох, ах дүү хамаатан садан, хамаарал бүхий этгээдүүдэд давуу байдлыг бий болгохтой хатуу тэмцэнэ.
- 3.4.6. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “шүгэл үлээх” гэх мэт олон нийтийн хяналтын механизмыг бий болгож, Авлигыг мэдээлсэн иргэдийг дэмжин орон нутгийн орон нутгийн түвшинд асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 3.4.7. Бүх нийтээрээ авлигатай тэмцэх, шударга бус зүйлийг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлж бүх төрлийн соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил хийнэ.

3.5. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Үндэсний аюулгүй байдлын бодлогыг орон нутгийн бүх бодлогод тусган хэрэгжүүлэх зарчмыг баримтална.

- 3.5.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.5.2. Хүнсний аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.
- 3.5.3. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хадгалж угийн бичиг хөтлөх аянд гэр бүлийг идэвхтэй хамруулах бодлого хэрэгжүүлнэ.

Аливаа гэмт хэрэг зөрчил, болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, хандлагыг төлөвшүүлж амар тайван аюулгүй орчныг бүрдүүлнэ.

- 3.5.4. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.
- 3.5.5. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж хүүхдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.
- 3.5.6. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гаднын сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.5.7. Аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийн ашиглалтыг сайжруулна.

Эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, эх орноо батлан хамгаалах үзэл хандлагыг төлөвшүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

- 3.5.8. Цэрэг, эх оронч үзэлд суурилсан “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах оюутны тоог шат дараатай нэмэгдүүлнэ.
- 3.5.9. Эрх орноо батлан хамгаалах, эх оронч үзэл хандлагыг төлөвшүүлэх хөтөлбөр, нэгдсэн арга хэмжээнд ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчдыг бүрэн хамруулна.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулж эрсдэлийг даван туулах чадавхыг нэмэгдүүлнэ.

- 3.5.10. Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий цогц эрсдэлийн менежментийг хэрэгжүүлнэ.
- 3.5.11. Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.5.12. Иргэдээ эх оронч сэтгэл, хандлагатай болгох, орон нутгаа хамгаалах, гамшиг, эрсдэлтэй нөхцөлд бүх нийтийн бэлэн байдлын чадавхыг дээшлүүлж, бие бялдын хөгжлийг нь дэмжиж, иргэний боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ.ЭХ БАЙГАЛЬ-ЭЭЛТЭЙ ОРЧИН

4.1.НОГООН ХӨГЖИЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог ханган ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

- 4.1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэн ногоон байгууламж нэмэгдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.1.2. Эко системийн тэнцвэртэй байдлыг хадгалахад үйл ажиллагаа, өөрийн хөрөнгөөр хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
- 4.1.3. Ногоон байгууламжуудын арчлалт хамгаалалтыг сайжруулна.

4.2. АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТ

Агаар, орчны бохирдлыг үүсгэгч эх үүсвэрүүдийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.

- 4.2.1. Ногоон хөгжлийн шийдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох боловсрол олгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Хот, суурин газарт агаар, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг арилгах ажлыг бүх түвшинд нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж, олон улсын стандарт нэвтрүүлнэ.
- 4.2.3. Хөрс бохирдуулагч нүхэн жорлонгийн тоог бууруулна.

- 4.2.4. Айл өрхүүдийг дулааны шугамд шат дараатай холбосноор агаарын бохирдлыг бууруулна.

4.3. БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ

Бэлчээрийн төлөв байдал, даацад тулгуурлан нөхөн сэргээлтийг хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.

- 4.3.1. Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх "Бэлчээр ашиглалтын тухай" журмыг батлан хэрэгжүүлнэ.
- 4.3.2. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сүргийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.
- 4.3.3. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 4.3.4. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулна.

4.4. УС АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Усны нөөцийг хамгаалах, бохирдол, хомсдолоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна.

- 4.4.1. Усан хангамжийн эх үүсвэрт цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулна.
- 4.4.2. Инженерийн хийцтэй уст цэгүүдийг байгуулж бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 4.4.3. Булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж тохижуулах ажлыг үргэлжлүүлнэ.

4.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

4417144353
ЕНОА0056 9025707

Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж ашиглах санаачилгуудыг дэмжин байгальд ээлтэй техник технологийг нэвтрүүлж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

- 4.5.1. Иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх замаар хог хаягдлыг бууруулна.
- 4.5.2. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн хогийн цэгийн ил задгай хаягдах хаягдлын хэмжээг бууруулна.
- 4.5.3. Дахивар бүтээгдэхүүн авах цэг байгуулна.
- 4.5.4. Дахивар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдтэй хамтарч ажиллана.
- 4.5.5. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангуулж хяналтыг сайжруулна.
- 4.5.6. Байгаль хамгаалагчтай болно.

ТАВ. “АЯТАЙ ТУХТАЙ, АЮУЛГҮЙ” ОРОН НУТАГ

5.1 ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

Хөдөөгийн сэргэлтийн бодлогыг эрчимжүүлж, орон нутагт аятай тухтай, аз жаргалтай амьдрах ээлтэй орчныг бүрдүүлнэ.

- 5.1.1. Сум хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.
- 5.1.2. Төр-Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг холбогдох стандартад нийцүүлнэ.
- 5.1.3. Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэх, дулаан алдагдлыг бууруулах, шугам сүлжээний засвар шинэчлэлтийг төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.
- 5.1.4. Нийтийн орон сууц барих хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж газрыг нь шийдвэрлэж өгнө.
- 5.1.5. “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж зорилтод бүлгийн иргэдийг хамруулна.
- 5.1.6. Гэр хорооллын замын уулзваруудад анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, толь байршуулж аюулгүй байдлын хангуулна.

5.2. ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН ХӨТӨЛБӨР

Байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах, малчдыг дэмжих “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

- 5.2.1. Хоршоо байгуулах хүсэлтэй иргэдийг бодлогоор дэмжиж, хоршоо байгуулах, банкны зээлд хамрагдах, үйл ажиллагаагаа тогтмол явуулах зэрэг бүхий л үе шатуудад аргазүйгээр ханган ажиллаж хоршоодын тоог нэмэгдүүлнэ.
- 5.2.2. Хоршоололд суурилсан хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 5.2.3. Хоршоодод тулгуурласан “Дайвар бүтээгдэхүүн боловсруулах”, “Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах”, цехүүдийг байгуулна.

ДЭЛГЭРЭХ МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанлд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.16 № 1-6/408

Танай _____-ны № _____-т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026

442505367

оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн дүгнэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 1-6/556 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 2024 оны ээлжит сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулахгүйгээр оролцохоор ирүүлсэн тул “НИЙЦСЭН” дүгнэлтийг хүргүүлж байна.

Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (...)-ийг хавсаргав.

Хувийг: Дорноговь аймгийн Ардчилсан намын хороонд

Хувийг: Дорноговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт:.....⁴ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ



БҮРЭН АРДЧИЛАЛ-БҮТЭЭЛЧ ДЭЛГЭРЭХЧҮҮД

ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

4117144353
EЮА0056 9025707

2024-2028

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Нэг. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ – ӨРХИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭС

Боловсрол, соёлын чиглэлээр

- Мэдээллийн технологийн дэвшил, орчин үеийн сургалтын арга технологид суурилсан УХААЛАГ ЦАХИМ СУРГУУЛЬ төслийг хэрэгжүүлэх
- Ерөнхий боловсролын сургуульд ухаалаг самбар, “ IQ board “ суурилуулна.
- Дотуур байрны тохижилтыг сайжруулж гэрийн нөхцөлд ойртуулах, халуун устай болгох, тогтмол ажиллуулах
- Авьяас, Ном зэрэг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийг хариуцсан зөвлөгөө, үйлчилгээний зөвлөл байгуулж хяналтыг сайжруулна. .
- Сургуулийн өмнөх боловсролын гэр цэцэрлэгийн сургалтыг зохион байгуулж Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, бусад сумдтай хамтран ажиллах, багш солилцоогоор ажиллах
- Үдийн цай хөтөлбөрийг чанаржуулах, орчин нөхцлийг сайжруулах.
- Улс, аймагт зохиогдох олимпиад, тэмцээнд оролцсон сурагчид, залуучуудыг дэмжих
- Дэлгэрэхийн хүүхдүүдийг сурталчлах, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг бусад аймаг суманд сурталчлах, хамтран ажиллах
- Сургууль, цэцэрлэг, бүх ангид ус нэвэршүүлэх төхөөрөмж тавьж цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.
- “ Дорноговийн хүүхдүүд японд 1000 сурагч” хөтөлбөрийн сурагч солилцооны ажилд Дэлгэрэхийн сурагчдаас хамруулах
- Багш нарын боловсролын зэргийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх бодлого арга хэмжээг авч ажиллах
- Орчин үеийн шаардлага хангасан Номын сан бий болгох
- Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн ур чадвартай болгох, хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтыг сайжруулна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ хамт суралцах таатай орчинг бүрдүүлнэ.
- Сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн байгуулан ажиллуулж үйл ажиллагааг дэмжинэ.

- Монгол бичгийн сэргээн дэлгэрүүлэх, сургаж өвлүүлэх, монгол бичиг заах арга зүй, цахим хэрэглээг төлөвшүүлнэ.
- Явуулын сургалтуудыг зохион байгуулах
- Хичээл сургуулиас гадуурх сонгон секц, дугуйлан хичээллүүлж, хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж хөгжүүлнэ.
- Залуу багш нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэн чадваржуулахад ахмад багш нарын зөвлөх үйлчилгээг зохион байгуулах
- Ерөнхий боловсролын сургалтад “Хүнсний тухай боловсрол”-ыг сурталчилна.

Соёл, урлаг, спортын чиглэлээр

- Соёлын төвийг мэргэжлийн боловсон хүчнээр хангана.
- Музейн тохижилт үйлчилгээг сайжруулна.
- Ёслол хүндэтгэлийн өргөөг тохижуулж, тогтмол үйлчилгээтэй болгоно.
- Нийтийн биеийн тамир арга хэмжээг хавар, намар тогтмол зохион байгуулна.
- Шатар, даам зэрэг оюуны спортыг хөгжүүлэх тусгай дугуйлан секц тогтмол хичээллүүлэх
- Үндэсний спортын төрлүүдийг хөгжүүлж, залуу үед өвлөн уламжлуулахыг дэмжинэ.
- Өрх бүр угийн бичиг хөтлөх санаачилгыг өрнүүлж ажиллана.

Эрүүл мэндийн төгс үйлчилгээ

- СӨБ, ЕБС – ийн сурагчдын шүдийг эрүүлжүүлэхэд анхаарч, Жилд 2 удаа шүдний эмчилгээ үйлчилгээнд хамруулах нөхцлийг бүрдүүлж ажиллана.
- Эмнэлгийн оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- Уламжлалт болон физик эмчилгээний өрөөтэй болох
- Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Сумын төвийн бохирын цооног, бие засах газруудыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэх
- Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг сум орон нутагт зохион байгуулна.
- Иргэн бүрийг насны бүлэгт тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- Өрхийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоог бүрдүүлж, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлнэ.
- Эмнэлгийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлж, асаргаа, сувилгааны чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Өрх бүр ундандаа цэвэр ус хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал

- Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулж байнгын болон түр ажлын байранд зуучилна.

- Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийтийг хамарсан ажлуудыг ил, тод, үр өгөөжтэй зохион байгуулна.
- Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.

Хариуцлагатай залуу манлайлагчид

- Залуучуудын хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ажиллана.
- Ажил идэвхтэй хайж байгаа залуусыг дахин сургах тал дээр анхаарч сургалтын байгууллагуудыг судлах
- Ажлын байр гарахад бүртгэлтэй ажил хайгчдаас Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн бүртгэлийн дарааллаар зуучлах бодлогыг баримтлана.
- Залуучуудын хөгжлийн төв байгуулна.
- Дугуй сонирхогчдын бүлэг байгуулах дэмжих замаар нийтийн дадал хэрэглээ болгоно.
- Залуу малчдыг дэмжих бодлого боловсруулж ажиллана.

Ахмадуудын талаар

- “Ахмадаасаа суралцъя, туршлага судалъя” хөтөлбөрийг хэрэгжүүлж ахмад залуу үеийн харилцаа холбоог үр дүнд чиглүүлнэ.
- Ахмадуудын эрүүл мэндэд анхаарч, ахмадуудыг сувилалд хамруулах, ахмадыг дэмжигч байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулна.
- Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхны төлөөх үйл хэрэгт ахмадуудыг оролцуулна.
- Ахмадын байрыг тохижуулж, тогтмол үйлчилгээтэй болгоно.

Өрх гэр бүлийн талаар

- Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжих зорилгоор “Гэр бүлийн тэмдэглэлт өдөр” –ийг тэмдэглэн сургалт зохион байгуулж гэр бүлүүдийн туршлагаас хуваалцаж судална.
- Өрх гэр бүлд угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлнэ.
- Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, залуу гэр бүлд амьжиргаагаа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг Төрийн бус байгууллагатай хамтран ажиллуулна.

Ажлын байр хөдөлмөр эрхлэлт

- Ажил хайгч, ажил олгогчийг шууд холбох хөдөлмөр зуучлалын мэдээллийн биет болон онлайн сүлжээг тогтмол ашиглаж хэвшүүлнэ.
- Ингэний фермер байгуулан эрүүл мэндэд тустай бүтээгдэхүүн боловсруулна, торомны ноос бэлтгэнэ.

- Бизнес эрхлэх арга зүйн сургалтуудыг явуулах, сургагч багш нар бэлтгэнэ.
- Иргэдийн оролцоонд тулгуурлан бүтээн байгуулалт, тохижилтын түр ажлын байруудыг бий болгоно.
- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, жижиг дунд үйлдвэрлэлийн уялдаа холбоог сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авна.
- Талх нарийн боовны цех байгуулна.
- Сур, арьс, ширэн эдлэлийн үйлдвэрлэл явуулахад дэмжлэг үзүүлнэ.
- Үсчин ажиллуулна.

Хоёр. ЧИНЭЭЛЭГ ӨРХ-ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

Жижиг дунд бизнесийн чиглэлээр

- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд орон нутгийн бизнес эрхлэгчид, аж ахуй нэгжүүдийг хамруулж, дэмжиж ажиллана.
- Бизнес эрхлэгчдэд байр, тоног төхөөрөмжийг ашиглуулж дэмжлэг үзүүлнэ.
- Малчдын бизнесийг дэмжиж “Чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.
- Тоног төхөөрөмж лизингийн үйлчилгээнд зуучилна.
- Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулахад бодлогоор дэмжинэ.
- “Өрхийн хэрэгцээг өөрийн хашаа”-аас төслийг хэрэгжүүлж хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлнэ.

Уул уурхайн чиглэлээр

- Орон нутгийн хэмжээнд ач холбогдолтой уул уурхайн төслүүдийг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, эдийн засагт өгөөжтэй байх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниудыг уулзалт, зөвлөгөөнд хамруулж, уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллана.
- Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.
- Байгаль орчинд сөрөг нөлөөлж буй уул уурхайн үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хяналт тавина.
- Уул уурхайгаас эвдрэлд орсон талбайг буруутай этгээдээр нөхөн сэргээнэ.
- Байгаль орчныг хамгаалах, хайрлах үзэл бодлыг хүүхэд залуучуудад төлөвшүүлэх сургалт сурталчилгааг зохион байгуулна.

Мэдээлэл технологи харилцаа холбооны чиглэлээр

- Цахим худалдаа, бараа хүргэлтийн системийг сайжруулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин, орон нутагт боломжоор хангана.
- Интернэтийн хурдыг сайжруулна.

Шугам сүлжээ, дэд бүтцийн чиглэлээр

- Төвлөрсөн уурын зуухтай болгох байгууллага, ААН Байгууллага, айл өрхийг нэгдсэн халаалтад холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- Сумын төвийн эрчим хүчний дотоод сүлжээний хүчин чадлыг сайжруулна.

Гурав. ГЭР ХОРООЛЛЫН ХӨГЖИЛ

- “ХАШААГАА САЙХАН ТОХИЖУУЛЪЯ” хөдөлгөөнийг өрнүүлж, гэр хороололд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- “ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЪЕ” төслийг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.
- Гэр байрны айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- Хашаандаа мод тарьсан айл өрхийг үр дүнгээр урамшуулна.
- Хүүхэд залуусын тоглоомын талбай, хөл бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.
- “ЖИШИГ ХАШАА, ГУДАМЖ, БАЙР” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Сумын өнгө үзэмжид нөлөөлөхүйц барилга барих, сэргээн засварлах ажилд хувийн хэвшил болон иргэдийн оролцоог дэмжинэ.
- Гэр байр болон гудамж талбайд гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх
- “ХҮЛЭМЖТЭЙ ХАШАА” хөдөлгөөнийг өрнүүлж, айл өрхүүд өдөр бүр эрүүл хүнсээр хангагдах нөхцлийг бүрдүүлнэ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр

- “ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- Хөдөөгийн малчин өрхийг дэмжин “малжуулах төсөл”ийг хэрэгжүүлнэ.
- Банди, Тайж адууны угшлыг улсын бүртгэлд оруулна.
- “Дэлгэрэхийн улаан ямаа” төслийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.
- Малчдын хөдөлмөр алдрыг жил бүр тэмдэглэнэ.
- Малыг индексжүүлсэн даатгал төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Нутгийн монгол үзэмчин хонины тоог нэмэгдүүлнэ.
- “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.
- Гурван гашууны шүүгээр малын тэжээл бэлтгэнэ.
- Эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан хүнс, мах, ногооны зоорь барих хувийн хэвшил болон иргэдийн санал санаачилгыг дэмжинэ.

- Гар худаг гаргах, сэргээн засварлах, иргэдийн санаачилгыг төсөл хөтөлбөрт хамруулан дэмжинэ.
- Хөдөөгийн багуудад гүн өрмийн худаг шинээр гаргах ажлыг улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөтөлбөр төсөлд хамруулан гүйцэтгэнэ.

Хог хаягдлын чиглэлээр

- Сумын хог хаягдлын менежментийг шинэчлэн, хур хогийг цэвэрлэн устгах ажлыг зохион байгуулна.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хог хаягдлыг ангилан ялгах мэдлэг олгох сургалтыг зохион байгуулна.
- Хог зөөврийн машиныг тогтмол ажиллуулна.

Аялал жуулчлалын чиглэлээр

- Байгалын үзэсгэлэнт газрыг аялал жуулчлалын мэдээллийн сүлжээнд холбоно.
- “Цонжийн чулуу”, ”Маналын найман суварга”-ыг түшиглэн аялал жуулчлалын маршрут гаргаж сурталчилна.
- Хөдөөгийн багийн төвүүдэд элсний гар бөмбөгийн талбай байгуулна.

Иргэндээ үйлчилдэг засаглал

- Ажлын байр гарахад хөдөлмөрийн биржэд бүртгэлтэй иргэдээс тохирох шалгуурыг хангасан иргэдийг зуучлан, томилох явцад төрөөс хяналт тавина.
- Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулан “Улсын тэргүүний сум” шалгаруулах болзолт уралдаанд оролцоно.
- Төрийн албан хаагчдын ажлын байран дахь сургалтыг мэдээллийн бүх хэлбэрийг ашиглан зохион байгуулна.
- Шинээр томилогдож буй албан хаагчдын тухайн ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн эсэхэд хяналт тавина.
- Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
- Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонголтын тухай хуулиудад туссан иргэний оролцоо, хяналтын боломжуудыг бодитоор хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Малын хулгайтай тэмцэх ажлын цар хүрээг өргөжүүлж, иргэд, олон нийтийн хяналт, хариуцлага, урамшууллын тогтолцоог бий болгоно.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.16 № 1-6/409

Танай _____-ны № _____-т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, орон нутгийн 2025-2026 оны төсвийн төсөөлөл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын

442505369

2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн дүгнэлтийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 1-6/530 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 2024 оны ээлжит сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрт өөрчлөлт оруулахгүйгээр оролцохоор ирүүлсэн тул “НИЙЦСЭН” дүгнэлтийг хүргүүлж байна.


Дорноговь аймгийн Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох “Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (....)-ийг хавсаргав.

Хувийг: Дорноговь аймгийн Ардчилсан намын хороонд

Хувийг: Дорноговь аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт:.....⁴ хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ



БҮРЭН АРДЧИЛАЛ-БҮТЭЭЛЧ ЗАМЫН-ҮҮДЧҮҮД

ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД

ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

4417144353
EЮA0056 9025707

2024-2028 он

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ

АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд **Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, эрх бүр аз жаргалтай амьдрах** хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНЫ 2024-2028 оны орон нутгийн сонгуульд оролцох “ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ танилцуулж байна.

Нэг. БҮТЭН МОНГОЛ, ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ

441714333
ЕЮА0056 9025707

1. ЦОГЦ БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Монгол эх орныхоо байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

- 1.1. Сумын боловсролын байгууллагуудыг өрсөлдөх чадварыг дээшлүүлж, улс, аймгийн хэмжээнд боловсролын салбарт амжилтаа ахиулах бодлогыг баримтална.
- 1.2. Ерөнхий боловсролын сургалтын гол зорилго нь эх оронч монгол хүнийг бэлтгэх явдал хэмээн үзэж, монгол хэл, уран зохиол, түүхийн хичээлийн цагийг нэмж, чанаржуулна.
- 1.3. Цахим орчинтой харилцах, цахим орчинд ажиллах чадвар эзэмшүүлэх боловсролыг дэмжинэ.

- 1.4. Хичээлээс гадуурх сургалт, дугуйлангийн хамрагдалтыг 75 хувьд хүргэж, суралцагчийн сонирхол, чадварыг нээн хөгжүүлэх сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөтгөнө.
- 1.5. Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- 1.6. Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.7. Бүх оюутныг сургалтын зээл авах тэгш боломжоор хангана.
- 1.8. Сурагчдын мэргэжил сонголтод түлхэц өгөхүйц сургалтын тусгай хөтөлбөрийг боловсруулж, чиглэл тус бүрд чиглэсэн төрөлжсөн сургалтын цахим сургалт болон кабинетуудыг нээнэ.
- 1.9. Ерөнхий боловсролын 1-р сургуулийг шинэчлэн барьж 2025 оны 2-р улиралд багтаах ашиглалтад оруулна.
- 1.10. 4-р сургуулийн барилгыг 2025 оны 1-р улиралд багтаан ашиглалтад оруулна.
- 1.11. Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.
- 1.12. Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаа, оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.

2. ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯЛАГ

- 2.1. Эрүүл мэндийн нэгдсэн оношилгоо, шинжилгээний бүх төрлийн үйлчилгээг Нэгдсэн эмнэлэгт нэвтрүүлж бүсийн оношилгооны төвийн хэмжээнд хүргэнэ.
- 2.2. Сум орон нутгийн байршлын давуу талаа ашиглан БНХАУ-н Хөх хот болон Бээжин хотын эмнэлгүүдтэй холбоо тогтоож алсын зайн оношилгооны төвийг байгуулна.
- 2.3. Сум орон нутагт ажиллахаар ирсэн өндөр мэргэшлийн боловсон хүчний нийгмийн асуудлыг цогцоор шийдвэрлэнэ.
- 2.4. Зайнаас оношлох системийг нэвтрүүлж гэрээсээ эмнэлгийн оношилгоо, хяналтыг авах боломжоор хангах "Цахим оношилгоо, хяналт" үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 2.5. Өрхийн эмнэлгийн үйл ажиллагаа болон түүнд ажиллаж байгаа боловсон хүчний асуудалд анхаарч бодлогоор дэмжин улсын эмнэлгийн жишигт хүргэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.6. "Сүүн шүд" тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхдийн амны хөндийн эрүүл мэндэд онцгой анхаарна.
- 2.7. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл зөв хооллолтын клубүүдийн үйл ажиллагааг бодлогоор

дэмжиж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг нийтийн дадал хэрэглээ болгохыг зорино.

- 2.8. Өрх, сумын эрүүл мэндийн төвд ажиллах эмчийг бодлогоор дэмжиж, тоог нэмэгдүүлнэ.
- 2.9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд резидент эмч нарын оролцоог нэмэгдүүлж, цалинг ажлын гүйцэтгэлтэй уялдуулна. Эрүүл мэндийн даатгалын цахим технологийг нэвтрүүлж, өвчтөнд эмнэлгээ сонгох эрхийг олгоно.
- 2.10. Уламжлалт анагаах ухааны анхан шатны эрүүл мэндийн болон нийтийн эрүүл мэндийн салбарт эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 3.1 "ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ"-ийг байгуулна. Зорилтот бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй сургалтын системийг хэрэгжүүлнэ.
- 3.2 Иргэдэд үйлчлэх хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ бүхий нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төвийг байгуулна.
- 3.4 Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй зорчих олон улсын стандартын шаардлагад нийцүүлж өөрчилнө.
- 3.5 Залуучуудын хөгжлийн "Community center" байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.
- 3.6 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг сумын хэмжээнд үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.7 Ахмад настанд зориулсан сэргээн засах, эмчилгээ, сувилгааны цогцолбор төвийг байгуулж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 3.8 Хамтын тэтгэврийн тухай хуулийг сэргээж, мөрдүүлнэ.
- 3.9 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар орон нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.
- 3.10 Хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулж, ясли, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4. ӨРХ ГЭР БҮЛ

- 4.1 Орон нутгийн иргэдийн Ипотекийн зээлд хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.
- 4.2 "Түрээсийн орон сууц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж Залуу гэр бүл болон, томилогдон ирж буй боловсон хүчнийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлнэ..

- 4.3 Өрх толгойлсон эх, эцэг-ийг хөдөлмөр эрхлэлтийн боломжоор хангах бодлогыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлнэ.
- 4.4 “ХАШААГАА САЙХАН ТОХИЖУУЛЪЯ” хөдөлгөөнийг өрнүүлж, гэр хороололд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 4.5 Инженерийн шугам сүлжээнд холбогдсон гэр хороололд амины орон сууц барих иргэнд амины орон сууц барих зээлд хамрагдах нөхцлийг бүрдүүлж орон нутгийн банкуудтай хамтран ажиллана.
- 4.6 “ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЪЕ” төслийг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулан, иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ. Сумын гэр хорооллыг нүхэн жорлонгүй болгох хөтөлбөрийг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 4.7 Гэр хорооллын өрх бүр хашаандаа мод тарих нэгдсэн арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулж ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” аянтай уялдуулж ажиллана.

5. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

- 5.1 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнд орон нутгаа төлөөлөн оролцох баг бүрэлдэхүүнийг дэмжих сан байгуулна.
- 5.2 Орон нутгийн музей байгуулна.

6. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

Мал аж ахуй

- 6.1 Залуу малчдыг малжуулах төслийг сэргээн хэрэгжүүлнэ.
- 6.2 “Шинэ зууны малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл хэрэглэх боломжийг бүрдүүлнэ
- 6.3 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ. Иргэдийн санаачилгад суурилсан “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 6.4 Малыг тооноос илүү чанарт анхаарч, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг төрийн бодлогоор дэмжинэ.
- 6.5 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

7. БИЗНЕС, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 7.1 Аж үйлдвэрлэл, технологийн хувьсгал, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухааны эрин үед өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээл, шинэ төрлийн ажлын байрны шаардлагыг хангах хөрвөх чадвар, өндөр мэдлэг бүхий мэргэжилтэн, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, сургах бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, ажлын байраар шууд хангагдах бололцоог бүрдүүлж ажиллана.
- 7.2 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр(цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрч, бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 7.3 Бизнес, хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжиж, дундаж давхаргын эгнээг тэлнэ.
- 7.4 Ажилгүйдлийн түвшинг 10 хувиас бага түвшинд байлгах хөдөлмөр эрхлэлтийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн даатгалын тогтолцоог бүрдүүлнэ.
- 7.5 Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 7.6 Хаягдал болон түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг бий болгож экспортод гаргах гарцыг нээнэ.
- 7.7 Жижиг дунд бизнес эрхлэгчдийг бизнес удирдах чадавхыг нь дээшлүүлэхэд анхаарал хандуулж, "Бизнес инкубатор" төвийг сэргээн байгуулж ажиллуулна.
- 7.8 Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуйн нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг тогтолцоог бий болгож цахимжуулна.
- 7.9 Инновацад суурилсан гарааны бизнесүүдийг дэмжинэ. Гарааны бизнесийг дэмжих экосистемийг бүрдүүлнэ.
- 7.10 Улс хоорондын зорчигч болон ачаа тээврийн үйл ажиллагааг жигдрүүлж, орон нутгийн тээвэрчдийг дэмжин ажиллахаас гадна Цахим биржийг байгуулж тээвэрчдийн эрх ашгийг хамгаалах төр болон хувийн хэвшлийн оролцоотой зөвлөл байгуулна. Орон нутгийн тээвэрчдэд зориулсан "Ногоон гарц"-ыг хилийн бүсэд байгуулна

8. ТАТВАР

- 8.1 2020-2024 онд аймаг сумын ИТХурлаар батлагдсан бүх төрлийн татварын нэмэгдлүүд болон хураамжуудыг цуцална

9. ХӨГЖЛИЙН ДЭД БҮТЭЦ

- 9.1 Замын-Үүд сумын газар эзэмшигч иргэдийн эзэмших эрхийг өмчлөх эрхийн хэлбэрт шилжүүлэх хуулийн гарцыг судлуулж шийдвэрлүүлнэ.

- 9.2 Замын Үүдийн Эдийн засгийн чөлөөт бүсийг эргэлтэд оруулж засгийн газар, яамд, аймаг орон нутгийн засаг захиргаатай нягт хамтран ажиллана.
- 9.3 “Сайн хашаа” төслийг сэргээн үргэлжлүүлж, хөдөлгөөн ихтэй гэр хороолол орчмын замуудыг бүрэн засмал замтай болгоно.
- 9.4 Сум дотор нийтийн тээврийн автобус үйлчилгээг сэргээн тогтмолжуулна.
- 9.5 Дугуйн замуудыг стандартын шаардлагад нийцүүлэн шинээр зам тавина.
- 9.6 Эрчим хүч түгээгч байгууллага болон хэрэглэгчдийн хамтын ажиллагааг сайжруулж, хэрэглээний хяналтыг цахимд шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.
- 9.7 Сумын гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, шугам сүлжээг өргөтгөнө.
- 9.8 Замын Үүд сумын иргэдийн цагийг хэмнэх, бизнес эрхлэгчид, жуулчдын ая тухтай байдлыг хангах зорилгоор Замын Үүд суманд шинээр онгоцны буудалтай болгож дотоодын агаарын тээврийн гарцыг нээнэ.

10. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

- 10.1 Сумын өрхийг хэсэгчлэн хийн түлшний системд холбож, утаагүй түлш үйлвэрлэгч жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- 10.2 Замын Үүдийн “НОГООН ХЭРЭМ” төслийг хэрэгжүүлнэ. Хөрш орны Эрээн хотоос туршлага судалж ойн мэргэжилтнүүдийг урьж ажиллуулна.
- 10.3 Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” аяны хүрээнд аж ахуй нэгж, өрх бүр хашаандаа мод тарих бодлогыг хэрэгжүүлж орчноо моджуулж ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 10.4 Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх асуудлыг нэгдсэн, цогц бодлоготой болгож, бие даасан орон нутгийн агентлагийг байгуулна.
- 10.5 Хиймэл нуур, хөв цөөрөм, цэцэрлэгт хүрээлэнгийн цогцолбор байгуулна.
- 10.6 Өрхийн амьжиргааг дэмжих бодлогын хүрээнд хүлэмжийн аж ахуй эрхлэгч иргэд аж ахуйн нэгжийг дэмжин тэдэнд орон нутгийн онцлогт тохирсон хүнс, жимс жимсгэнэ ногооны үрээр ханган дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж өгнө.

11. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 11.1 Хил орчмын аялал жуулчлалыг сэргээж орон нутгийн урлаг соёл, худалдаа үйлчилгээ, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

12. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

- 12.1 Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхтай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө тэгш хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо,

- мэргэжлийн, хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.
- 12.2 Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цахим орчинд хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээлэл, нууц, өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.
- 12.3 Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
- 12.4 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх тогтолцоог боловсронгуй болгоно.
- 12.5 Шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн байгууллагуудын саналыг авдаг, зөвлөлдөх зарчимд тулгуурладаг тогтолцоог бүрдүүлнэ.
- 12.6 Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
- 12.7 Цагдаагийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулж, орчин үеийн техник хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлэнэ.
- 12.8 Нийтийн эзэмшлийн зам талбай автозамыг камержуулж, хяналтын нэгдсэн сүлжээнд холбоно.
- 12.9 Ган, зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан бэлэн байдлын нөөцийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 12.10 Архидалт, мансууралтай тууштай тэмцэж, хорт зуршлыг эрс бууруулна.

